| | |
|---|---|
| Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/ | |
| Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй. | |
| | |
| Тайлагнах хугацаа | 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдөр |
| Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар | "МИК Холдинг" ХК, 9010001134 , MSE:MIK, 11-328267 |
| Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр | Монголын хөрөнгийн бирж |
| Бизнесийн үйл ажиллагааны салбар | Санхүүгийн бусад үйл ажиллагаа |
| Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг | 20,709,320 |
| Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр | Хянасан: Гүйцэтгэх захирал Б.Гантулга |

| | | |
|---|---|---|
| 1. | Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/ | |
| | Санхүүгийн байдлын үзүүлэлт | Тайланг хавсаргав. |
| | Орлогын тайлан | Тайланг хавсаргав. |
| | Өмчийн өөрчлөлтийн тайлан | Тайланг хавсаргав. |
| | Мөнгөн гүйлгээний тайлан | Тайланг хавсаргав. |
| | | |
| 2. | Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт | |
| | 2022 оны 7 дугаар сарын 26-ны өдөр Санхүү аудитын хорооны хуралд “МИК Холдинг” ХК-ийн 2 дугаар улирлын санхүүгийн тайланг танилцуулж, 10 дугаартай дүгнэлтээр баталгаажсан. | |

<table>
<tr><td>3.</td><td colspan="2">Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</td></tr>
<tr><td>3.1.</td><td>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</td><td rowspan="2">
<table>
<tr><td colspan="2">Санхүүгийн үзүүлэлтүүд</td></tr>
<tr><td colspan="2">Ашигт ажиллагаа</td></tr>
<tr><td>Цэвэр хүүний маржин (NIM) *</td><td>0.02%</td></tr>
<tr><td>Нийт хөрөнгийн өгөөж (ROA) *</td><td>2.17%</td></tr>
<tr><td>Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) *</td><td>2.32%</td></tr>
<tr><td colspan="2">Өөрчлөлтийн хувь (оны эхнээс)</td></tr>
<tr><td>Нийт активын өөрчлөлт</td><td>-0.08%</td></tr>
<tr><td>Зээлийн багцын өөрчлөлт</td><td>1.16%</td></tr>
<tr><td colspan="2">Хөрөнгөнд эзлэх хувь</td></tr>
<tr><td>Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө</td><td>94.39%</td></tr>
<tr><td>Өр төлбөр/Нийт хөрөнгө</td><td>5.61%</td></tr>
<tr><td>Хөрвөх чадварын харьцаа</td><td></td></tr>
<tr><td>Хөрвөх чадвартай хөрөнгө / Татан төвлөрүүлсэн хөрөнгө</td><td>78.55%/5.07%</td></tr>
</table>
</td></tr>
<tr><td>3.2.</td><td>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</td></tr>
<tr><td>3.3.</td><td>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</td><td>Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн чуулганаар “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулж, хуулийн үйлчлэх хугацааг дахин 6 сарын хугацаагаар сунгасан.<br><br>Хуулийн үйлчлэх хугацаатай уялдуулан Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг Монголбанкнаас холбогдох байгууллагуудтай хамтран дахин 6 сарын хугацаагаар буюу 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлуулахаар шийдвэрлэсэн.<br><br>Ипотекийн зээл хойшлуулах 4 болон 5-р хөтөлбөрийн хүрээнд нийт 45,550 зээлдэгч ипотекийн зээлийн эргэн төлөлтөө хойшлуулах хүсэлтээ харилцагч банкууддаа цахимаар ирүүлсний дагуу үйлчилгээ үзүүлэгч банкууд хүсэлтүүдийг шийдвэрлэн ажилласан.</td></tr>
<tr><td>3.4.</td><td>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</td><td>Тайланг хавсаргав.</td></tr>
</table>

| | |
|---|---|
| 4. | Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/ |
| | Менежментийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор “МИК Холдинг” ХК нь өөрийн охин компани болох “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-тай 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр ДГ-22/02-02-1 дугаартай “Менежментийн үйлчилгээ үзүүлэх” гэрээг байгуулсан.<br>Чөлөөт мөнгөн хөрөнгийг хадгаламжид байршуулах зорилгоор “МИК Холдинг” ХК нь Худалдаа хөгжлийн банктай 2022 оны 5 дугаар сарын 6-ны өдөр 800014483 дугаартай “Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ”, 2022 оны 6 дугаар сарын 23-ны өдөр 800016189 дугаартай “Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ”-г тус тус байгуулсан. |
| 5. | Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл |
| | Байхгүй. |
| 6. | Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл |
| | “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн хурал нийт хоёр удаа хуралдаж, найман шийдвэр гаргалаа. ТУЗ-ийн дэргэдэх Санхүү, аудитын хороо нэг удаа, Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо хоёр удаа, Эрсдэлийн удирдлагын хороо нэг удаа тус тус хуралдаж, холбогдох дүгнэлтийг гаргасан байна. |
| 7. | Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл |
| | Тайлант хугацаанд дараах мэдээлэл, тайланг хүргүүлсэн. Үүнд:<br>• 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулж, хуралдуулсан талаарх тайлан;<br>• “МИК Холдинг” ХК-ийн засаглалын үнэлгээ. |

| |
|---|
| Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо: |
| Овог, нэр: Б.Гантулга<br><br>Албан тушаал: “МИК Холдинг” ХК-ийн гүйцэтгэх захирал<br><br>Гарын үсэг:……………………………………………..<br><br>(Тамга/тэмдэг) |
| Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: |
| Овог, нэр: Г.Саруул<br><br>Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга<br><br>Гарын үсэг: ……………………………………………….. |